



ХИЧЭЭЛ 7

УНШИХ ЗҮЙЛ: ҮЙЛС 16:6-15; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 211,212,218.

Манай Тэрт Хүрээд Ир

Та нар айлд зочлох дуртай юу? Тэгвэл гэртээ хүн урих дуртай юу? Лудиа Есүсийн тухай сонсоод шинэ найзуудаа гэртээ байрлахыг урьжээ. Тэр цагт нэг иймэрхүү явдал болсон байж магадгүй.

П

аул нүдээ нээлээ. "Хөөе, унтаахайнууд аа" гэж тэрээр Силас, Тимот, Лук зэрэг найзуудаа дуудлаа. "Босоорой, бүгдээрээ Македони руу явцгаая."

Силас, Тимот болон Лук нар нүдээ нухаллаа. "Хаашаа явна гэж чи сая хэлсэн бэ?" гэж Тимот асуув. "Өнгөрсөн шөнө Бурхан надад нэгэн

үзэгдэл үзүүллээ" гэж Паул тайлбарлаад "Нэгэн хүн надаас Македони руу ирж манай нутагт Есүсийн тухай сайн мэдээг тунхаглаж өгөөч гэж гуйхыг би үзсэн" хэмээв.

Паул найзуудтайгаа хамт нэгэн том дарвуулт завинд суулаа. Македони ортол удаан аялах хэрэгтэй боловч Бурхан салхи илгээж тэднийг хурдан хөвүүлжээ. Таван

Цээжлэх Ишлэл:

"Манайд ирж байгаач"
үйлс 16:15.

Тол Санаа:

Бусдын төлөө санаа тавьж байхдаа бид Бурханд үйлчилдэг.



өдрийн дараа тэдний завь Македонид ирж зогсов.

Паул найзуудынхаа хамт Филиппой гэдэг том, хөл хөдөлгөөн ихтэй, чухал хотоор алхлаа. Шаббат өдөр тэд голын эргээр алхсан байна. Шаббат өдөр бүр голын эрэг дээр хүмүүс цугларч Бурханыг магтан хүндэтгэдэг гэж тэд сонссон байжээ.

Тэд тийнхүү алхаж явахдаа хэсэг эмэгтэйчүүдийг олж харав. Тэр үед эмэгтэйчүүдийг олон хүмүүс тоодоггүй байжээ. Гэвч Паул тийм байсангүй. Есүс эмэгтэйчүүдийг яг өөрийг нь хайрладаг шиг хайрладаг гэдгийг тэр сайн мэддэг байсан.

Тэд эмэгтэйчүүд дээр очихоор шийдлээ. Паул болон түүний нөхөд эмэгтэйчүүд дээр очоод ярих юм байна гэж хэлэхэд эмэгтэйчүүд баахан эмээжээ. Тэнд байсан эмэгтэйчүүд Бурханы тухай мэддэг бас Түүнд итгэцгээсэн байжээ. Харин одоо тэд Бурханы хүү, Есүсийн тухай сонслоо.

Бурхан тэдний сэтгэл зүрхийг нээв. Тэд Паулын ярьсан гайхамшигтай сайхан зүйлийг сонсоод итгэжээ. "Би усан баталгаа хийлгэхийг хүсэж байна" гэж Лидиа хэллээ. "Би гэртээ хариад хүмүүст Есүсийн тухай ярьж өгөхийг хүсэж байна."

Лудиа бол наймаа эрхэлдэг баян эмэгтэй байсан юм. Тэрээр зөвхөн хаан хатдын өмсдөг нил ягаан өнгийн даавуу худалддаг байжээ. "Та бүхэн Филиппой хотод сайн мэдээг тунхаглаж байхдаа манай гэрт үлдэж байрлаач" гэж тэрээр Паул болон түүний найзуудаас гуйсан байна. Паул, Тимот, Силас болон Лук нар Бурханд үйлчлэхээр нутагт нь ирсэн гэдгийг Лудиа сайн мэдэж байсан юм.

Лудиа ч гэсэн Паул болон түүний найзуудыг халамжилж Бурханд үйлчлэхийг хүссэн байна.

Паул найзуудтайгаа хамт олон өдрийн турш Филиппой хотод сургаал заажээ. Есүсийн тухай баярт мэдээнд олон хүн итгэж, миссионерууд болон Лудиагийн Бурханд өргөсөн үйлчлэлийн улмаас усан баталгаа хүртсэн байна.



Дасгал Ажил

ШАББАТ

Энэ долоо хоногт өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ уншаад цээжлэх ишлэлээ хөдөлгөөнтэй нь хийгээрэй.

МанайӨөр рүүгээ заах.

гэрт ирээдХуруугаараа гэрийн дээвэр дүрслэх.

өнжиж байгаачГараа цээж рүүгээ болгох.

Үйлс 16:15Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Хүүхдээ нэг найзаа урьж гэртээ хамт тоглооч гэж хэлээрэй. Эсвэл хэн нэгнийг оройн хоолонд уриарай. Хүүхэд чинь Найзаа урих хаалганд өлгөдөг зүйлээ өрөөний эсвэл үүдний хаалган дээр өлгөг. Асуух: Хүмүүс чамд яаж анхаарал халамж тавьдаг вэ? Бусдыг чи яаж халамжлах вэ?

ДАВАА

Үйлс 16:6-15-г хамтдаа уншаарай. Асуух: Лудиа Паул болон түүний найзуудад яаж тусалсан бэ? Паул Лудиад яаж тусалсан бэ? Хэн нэгнийг гэртээ урихын тулд заавал том байшинтай байх хэрэгтэй юу? Энэ долоо хоногт нийтийн асрах газар руу хүүхдээ дагуулж явахаар төлөвлө. Энэ долоо хоногийн Шаббат хичээл дээр болох нийтийн тустай үйлчлэлд зориулсан зүйлийг цуглуулаарай.

МЯТГАР

Гэртээ эсвэл хөршийнд чинь харагдаж байгаа нил ягаан өнгийн зүйлсийг тоолно уу. Хүүхдээрээ ягаан өнгө гаргуулаарай. Улаан цэнхэр хоёр өнгийн харандаагаар давхар будуулах эсвэл улаан цэнхэр хүнсний будгийг усан дотор найруулуулаарай. Хаан



хатад хэрхэн ягаан өнгийн хувцас өмсдөг байсан тухай ярьж өгөөрэй. Хэрэв боломжтой бол ямар нэг ягаан өнгийн зүйл өмсөөрэй.

ЛХАТВА

"Гэр бүлээрээ Есүстэй хамт" гэдэг дууны аян дээр Найзууд маань манайд ирэхэд манайх аз жаргалтай айл болдог гэдэг үгийг орлуулж дуулаарай.

Найзуудынхаа нэрийг дурдаарай. Библийн газрын зургийг хүүхдэдээ харуулаад Паул хаагуур аялсныг тайлбарлаж өгөөрэй. Паулыг дуурайж хүүхэдтэйгээ хамт гэрийнхээ ойр орчмоор алхаарай.

ЛҮРЭВ

Зочинд яаж хандах тухай ярьж өгөөрэй. Гэрийхнийгээ хүүхдээрээ үүдэн дээр угтуулж сургууль хийлгээрэй. Тэднээс юу уух вэ гэж асуулга. (Танай улсын хувьд юу зохистой вэ гэдгийг зааж өгөөрэй.)

БААСАН

Өнөөдөр оройн хоолон дээрээ ягаан өнгийн салфетка, алчуур тавиарай. Хоолондоо нэг ягаан өнгөтэй хоол эсвэл уух юм бэлдээрэй. Хуваалцах дууг хамтдаа дуулна уу. Түүхийг ярьж өгөхдөө хүүхдээрээ тусалцуулаарай. (завийг хайрцгаар төлөөлүүлэх, Лудиагийн хувцсыг ягаан даавуугаар төлөөлүүлэх г.м.)

